

“НОЁН ЖАНГАРЫН ГЭР” МАГТААЛ БОЛОН “ЖАНГАР” ТУУЛИЙН ХАРЬЦУУЛАЛТ

Тэргэл, ӨМИС

Abstract: The research aimed on comparative study on the two contents, pedigree and Orgoo Ger, respectively appeared in the chant “The House of Master Jangaar” spread among Subei Mongolian and the novel Jangaar. Moreover, the research proved that the novel Jangaar was also spread from mouth to mouth among Subei Mongolian. Furthermore, the research pointed out the inheritance and distribution of the novel Jangaar. For achieving the research purpose, the research focused on the following three respects: the unified explication of the research progress, the comparison on the pedigree between the chant “The House of Master Jangaar” and the novel Jangaar and Orgoo Ger appeared in the chant and the novel.

Described about Jangaar’s ancestor and Orgooger description of the Subei Mongolian praise “The House of Master Jangaar” is same as Jangaar’s ancestor and Orgooger description of Kalmyk and Shinjaan Mongolian’s heroic epic “Jangaar”

-In other words, the Jangaar’s ancestor and Orgooger of description described in “The House of Master Jangaar” it is that can be considered as a part of oral tradition of novel “Jangaar”. It is proved by other scientists’ research work as well as my research work.

-We have to re-consider the one-sided idea about there was no other territory that has tradition of novel “Jangaar” other than Kalmyks of Russian Federation and Shinjaan of People’s Republic of China as well as western part of Mongolia.

Түлхүүр үг: Сүвэй монголчууд, “Ноён жангарын гэр”, Жангарын уг удам, өргөө гэрийн дүрслэл, “Жангар”-ын уламжлал ба тархалтын байдал.

Удиртгал

Тус өгүүлэлд Сүвэй Монголчуудын дунд өнөөг хүртэл уламжлагдан ирсэн “Ноён жангарын гэр” хэмээх магтаал дуу дахь Жангарын уг удам, түүний өргөө гэрийн дүрслэл зураглалыг “Жангар” тууль дахь Жангарын уг удам хийгээд өргөө гэрийн дүрслэл зураглалтай харьцуулан судалж болно. Сүвэй Монголчуудын дунд “Жангар”-ын аман уламжлал байсан гэдгийг нотлохын зэрэгцээ “Жангар”-ын уламжлал ба тархалтын тухай өөрийн санаа дүгнэлтийг дурдсан билээ.

Судалгааны ажлын хүрээнд нэгдүгээрт: “Жангар” туулийн нийтлэг өгүүлэмж ба судлагдсан байдлаас тоймлох, хоёрдугаарт: “Ноён Жангарын гэр” магтаал ба “Жангар” туулийн өгүүлэмж дэх Жангарын уг удмын талаар харьцуулах, гуравдугаарт: “Ноён Жангарын гэр” магтаал ба “Жангар” туулийн өгүүлэмж дэх Жангарын өргөө гэрийн талаар харьцуулан судлах зорилтуудыг дэвшүүлсэн билээ.

Монголын уран зохиолын эрдэнэсийн санд орсон гарамгай бүтээлийн нэг нь үргэлжийн өвөлгүй хавар, зунгүй намраар, даарах хүйтэнгүй, халах халуунгүй, сэр сэр салхитай, бур бур хуртай, Бумбын орны үхэлгүй мөнхийн, үргэлжид хорин

таван настай байдаг Жангарийн тухай тууль мөн. “Жангар” тууль нь хаана Монголчууд байна, тэнд уламжлагдан өвлөгдөж, нутаг орон бүрт харилцан адилгүйгээр уламжлагдсан онцлогтой. Иймээс Сүвэй Монголчуудын дунд тархсан “Жангар”-ын хувилбар уламжлалыг судлах явдал чухал юм.

Нэг. “Жангар” туулийн судлагдсан тойм ба нийтлэг өгүүлэмж

“Жангар” туулийг анх 1804 онд Германы эрдэмтэн В.Бергман Халимагаас илрүүлэн, түүнийгээ герман хэлээр тайлбартайгаар орчуулан хэвлүүлсэн юм. Түүнээс хойш Монгол, Орос, Герман, Америк, Япон зэрэг олон орны эрдэмтэд энэхүү туулийг судалсан боловч одоо болтол түүнийг бүрэн судалж чадаагүй байна. 1910 оны орчим Оросын эрдэмтэн В.Л.Котвич тэмдэглэн авч хэвлүүлсэнээс хойш Монгол, Халимаг, Хятадын Шинжааны өөрөө засах орны нутгаас олон арван бүлгүүд олджээ.

Одоо “Жангар” туулийн Халимаг, Шинжаан, Монгол гэсэн үндсэн гурван хувилбар байгаа бөгөөд үүнд Монголд 20 орчим бүлэг, Халимагт 30 орчим бүлэг, Шинжаанд 70 орчим бүлэг мэдэгдээд

байна” (Дэлэг, 2012).

"Жангар" туулийн судлал үүсч хөгжөөд хоёр зуу шахам жил болж байгаа тул цуглуулж, судлах ажилд нэлээд ахиц гарч нарийвчилсан судалгаанууд хийгдэж байна. Гэвч зарим судалгаанд шүүмжлэлтэй хандууштай хандлага байгааг тэмдэглэх нь зүйтэй. Тухайлбал, зарим зохиогч өөрийн хувийн үзэл бодлыг урьтал болгосны үндсэн дээр түүндээ тохирсон баримт эрж, эвлүүлэн тавьж байгаа нь уг туулийн үнэн байдлыг гуйвуулахад хүргэсэн байна.

"Жангар" судлалаар П.Поуха, Монголын эрдэмтэн Х.Лувсанбалдан, Р.Нарантуяа, Өвөр монголын У.Буянхишиг, Н.Содном нарын бичсэн чансаатай өгүүллүүд байгааг дурдах нь зүйтэй. Өдгөө өөрийн үндэстний цөөн бүлгүүдийн доторх соёл урлагийн хүрээнд харьцуулан улам гүнзгийрүүлэн судалбал "Жангар" судлалын цөөнгүй тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадах нь лавтай.

Тийм зорилгын үндсэн дээр тус өгүүлэлд Сүвэй Монголчуудын доторх "Жангар"-ын туулийн уламжлалыг эрэлхийлж байгаа билээ.

Туулийн нийтлэг өгүүлэмж нь Жангарын өөрийн цадиг намтар, орон нутаг, өргөө гэр, дайчин нөхөд, гавьяат үйл бүтээлийг нь ерөнхийлөн дурдсан удиртгал чанартай эхлэлээс гадна олон бүлэг бүхий том хэмжээний баатарлаг тууль юм.

Зохиолын "Эхлэл" хэсэгт Жангар баатар эрхэн 2 насандаа догшин мангаст нутгаа дайлуулж, өнчин биеэр үлдсэн боловч 3 насандаа Гулжин их мангасыг номдоо оруулж, 4 насандаа Дөрдөн шар мангасыг номхотгож, 5 насандаа Тахийн таван шулам хааныг олзолж, 6 насандаа зуун жадын үзүүр хугалж, Хүнхээн Алтан Цээж баатрыг эрхэндээ оруулж, энгийн олон баатруудынхаа барууны ахлаач болгож, долоотойдоо доордын долоон орныг доройтуулж, дуутай Жангар нэрээ дурсган, дөрвөн зүгийнхээ дөчин хааны нутгийг номдоо оруулж, тивийн дөрвөн хааны хүүхнүүдийг голоод, нар гарах, үд хоёрын хооронд байдаг

Ном төгс хааны охин Агай Шавдалтай гэрлэн, үргэлжид хорин таван настай дүрээрээ, үхэлгүй мөнхийн Бумба орныхоо арван давхар, есөн өнгийн алтан торлог байшиндаа төр шажин хоёроо зарлиг болоод сууж байгаа тухай өгүүлсэн байдаг.

Туулийн гол үзэл санаа нь эх нутаг, улс үндсээ хамгаалахыг ухуулсан зохиол юм. Ийм

учраас энэ зохиолыг монголын феодалын тархай бутархай улс нэгдэж байх үе ХҮ зууны дунд хэрд зохиогдсон болов уу гэж судлаачид үздэг. Туульд эв нэгдлээ чандлан сахиж, эрх жаргалаа хамгаалж чадах баатар эрийн тухай ард түмний хүсэл мөрөөдөл илэрч байна. Зохиолд Жангараас гадна Араг Улаан-хонгор, Догшин хар Санал, Хүнд гарт Савар, Орчлонгийн сайхан Миньяан зэрэг олон баатар гарна. Эднийг найз нөхдийн элбэрэл журам, эрх чөлөө зол жаргалын төлөө амь хайргүй тэмцэх чин хүсэл, шударга сайхан сэтгэл нэгтгэн байдаг.

Зохиолын гол баатар Жангар бол үнэн мөн, шударга, ариун ёс, эрх жаргалын төлөө тэмцэгч учраас зөв бодол, холч хараа, үнэнч хүмүүс түүнийг тойрон хүрээлж байна. Жишээ нь, Булингарын хүү Догшин хар Санал нь Буян төгс аавыгаа буянгүй орхиж, бурхан сайхан ээжийгээ хөвгүүнгүй орхиж, Бумбын сайхан хатнаа ганц биеэр орхин Жангартай нийлсэн бол Орчлонгийн сайхан Миньяан нь уугуул нутаг албат иргэд, ар гэрээ ардаа үлдээн Жангарыг түшсэн аж. Энэ мэтчилэн журмын олон нөхөд нийлж, нэг нь нөгөөгөө түшиж, нөгөө нь нэгийгээ хамгаалж байсан нь, хоёр настайдаа өнчирч, хожим нь харь дайсанд олзлогдон арайхийн амь гарч байсан Жангар баатар дайсныг дарж, аз жаргалаа бадраан, алдар нэрээ дуурсгахын уг сурвалж болжээ.

Иймд Жангар бол эх нутгаа жаргалын орон болгох гэсэн ард түмний орь хүслэнг илэрхийлсэн зохиол бөгөөд Оросын монголч эрдэмтэн Б.Я.Владимирцовын бичсэнээр "нүүдлийн амьдралын бадрангуй, уран зураглал" бүхий чухам монгол үндэсний чанартай туульсын зохиол юм. "Жангарын тууж" нь агуулга, зохиомж, уран сайхны талаараа баатарлаг туульд хамаарна. Зохиолд монгол ардын олонх баатарлаг туульс адил зовж зүдэрсэн доорд хүү /Жангар/, шадар сайн нөхдийн тус дэмжлэгтэйгээр харгис хаад, эзэд, аймшигт мангасыг дарж, аз жаргалаа олж, амар сайхан жаргаж байгаа тухай өгүүлсэн байна.

Хоёр. "Жангарын гэр" хэмээх Сүвэй Монголчуудын магтаал

Монголчуудын ардын аман уламжлалын үнэт бүтээл болох "Жангар" тууль нь уламжлагдан тархсаар өнөөг хүрч, XVII зууны эхэн үеэс гадаадын эрдэмтэн судлаачдын анхаарлыг татаж ирсэн байна. Гэтэл энэ хүрээнд зарим судлаачид "Жангар" туулийг Ойрад монголчуудын гол нутаглаж байх газар орноос (Оросын Холбооны Улсын Халимаг, Хятад Улсын Шинжаан, жич

Монгол улсын баруун хэсэг) өөр газар нутагт “Жангар” туулийн уламжлал ер байсангүй (Ланзай, 2004) гэх, эсхүл “Ойрдын түүхийн тусгал” (Алтан-Оргил, 1995) хэмээх буюу “Төв ойрдын бүтээл” (Төвийн үндэстэний дээд сургууль, 1984) гэх өрөөсгөл үзэлтнүүдийг дурдсан байдаг. Эдгээр үзэл ёсоор бол Сүвэй Монголчуудын дунд “Жангар” тууль огт уламжлагдаагүй гэж үзэхэд хүрдэг.

Гэтэл Сүвэй Монголчуудын дотор “Ноён жангарын гэр” гэх “Жангар” туульд холбогдох бүтээлийн өгүүлэмж, дүрслэл нь “Жангар” туулийн зарим хэсгийн тодорхой агуулгатай төсөөтэй юм. Ийнхүү тус өгүүлэлд Сүвэй Монголчуудын магтаал дуу болох “Ноён Жангарын гэр” дэх Жангарын овог удам болон өргөө гэрийн дүрслэл зураглалыг Халимаг буюу Шинжааны “Жангар” тууль дахь ижил төстэй дүрслэл зураглалтай харьцуулан судалж, “Жангар” тууль ба Сүвэй Монголчуудын ардын аман уламжлалын харьцаа холбоог шинжлэх замаар “Жангар” туулийн уламжлал тархалтын орны тухай өөрийн саналаа дэвшүүлэхийг зорив. Ийнхүү “Ноён Жангарын гэр” болон “Жангар” туулийн харьцаа холбоог:

Жангарын уг удмын дүрслэл

Өргөө гэрийн дээврийн дүрслэл гэсэн хоёр талаас нь авч үзье.

Жангарын өвөг дээдэс хийгээд уг удмын дүрслэл

“Жангар” туульд Жангар болон түүний баатруудыг магтахаар барахгүй, тэдний өвөг дээдсийн нэр алдрыг үе дамжуулан дуудах хайллагын хэвшил байдаг. Зуунайн гар бичмэл “Жангар” туулийг (цаашид Зуунайн “Жангар” гэж товчилъё) “Алдар торц хааны үг тохом, мэргэн торц хааны үр өлтөр, манхан магнай тариачин аавын, хөвгүүдийн үе дарааны шилжээс”-д “давхи, давхи начин хааны хөвгүүн орь гагцхан билээ ... 2-үе, даахь даахийн хааны хөвгүүд таван болно” (Таяа, 2006, х.7-8) хэмээж, “Үйзэн зул алдар хаан өргөө өргөөлсөн бүлэг”-т “давхи давхи начны талийх, даахь даахийн Жилийх, Тахил зул хааны жич, Тансаг бумба хааны ач, Үйзэн алдар хааныхан байдагсанжээ” гэж Жангарын өвөг дээдэс, уг удам нь хэнийх болохыг өгүүлж байна (Таяа, 2006, х.15). Аримпилын “Жангар” хорин гурван бүлэг (цаашид Аримпилын “Жангар” гэж товчилъё)-ийн “Жангарын эхний бүлэг”-д “Алдар Жангарыг /хэлдэг болохул тань/ давхи давхи начин /Тансаг бумба хааны ач/ Үйзэн алдар

хааны /ууган хөвгүүн/ үеийн өнчин Жангар гэж хэлдэг” (Таяа Д, 2013, х.2) гэж Жангар хааны дээдсийг дөхөмөөр өгүүлж байна. Гэтэл Сүвэй Монголчуудын магтаал “Ноён жангарын гэр”-д “давхи давхи тавуул гэнэ /давхийн ач нь/ ноён Жангарынхан гэнэ” (Чойдандар, 2014, х.10) хэмээн ноён Жангарын өвөг дээдэс нь хэн болох, хэдүүл болохыг ч магтаалын эхэнд танилцуулж байна. Ийнхүү Шинжаан буюу Халимаг “Жангар” хийгээд Сүвэйгийн “Ноён жангарын гэр” дэх Жангарын өвөг дээдэс, уг удмыг танилцуулсан тогтмол хэллэгт гол магтаж бүхий баатар нь цөм Жангар байж, тэр нь “Давхи давхи” гэдэг хааны хойчис гэдэгт санаа нэгдэж байна. Гэхдээ “Ноён Жангарын гэр” дэх энэхүү Жангарын өвөг дээдэс, уг удмын тухай агуулга нь “Жангар” туулийг бодвол арай хураангуйлж дөхөмчилсөн байдалтай.

Үүнээс үзэхэд, “Ноён Жангарын гэр” гэх энэхүү магтаал дуу бол “Жангар” туулийн Сүвэй монголчуудын дундах уламжлалын нэг хэсэг болох нь тодорхой байна.

Өргөө гэрийн дээврийн дүрслэлийн харьцуулал

“Жангар” туулийн эхлэл хэсэгт Жангар, түүний баатруудыг магтан танилцуулахаас гадна Жангарын орд өргөөг ч гойд сайхан хэл хэллэгээр дүрслэн хайлдаг. Овоолойн арван бүлэг (цаашид Овоолойн “Жангар” гэж товчилъё) “Жангар” туулийн “Арслангийн араг улаан Хонгор араг манзын бууралтай айх догшин магнай хаантай байр барилдсан бүлэг “-т “ар биеэр нь өвөлжсөн улс айраг химирээр гарах гэж алаг бухын арьсаар өнгөлсөн, Өмнө биеэр нь өвөлжсөн хүмүүн өөхөн тосоор гарах гэж үлэг бухын арьсаар өнгөлсөн” (Таяа, 2012, х.32) хэмээн дүрслэхэд, Зуунайн “Жангар”-т “алаг бугын арьсаараа \ ар дээврээ дэлдэв\ ... өл бугын арьсаараа өмнө дээврээ дэлдэв” (Таяа, 2006, х.334) гэж Жангарын өргөөний ар, өмнө дээврийг алаг буга, өл бугын арьсаар дээвэрлэснээр дүрсэлдэг. “Ноён Жангарын гэр”-д “гэр юуг нь хэлэн сурдаг болохноо /өмнө дээвр нь/ өл бугын арьсаар алтан хийсэн гэнэ ... ар дээврийг нь хэлэн сурдаг болохноо /алаг бухын арьсаар/ алтан хийсэн энэ санжээ гэнэлэй” (Чойдандар, 2014, х.410) хэмээн дүрсэлж байна. Үүнд, “Ноён Жангарын гэр” дэх уг дүрслэл нь Зуунайн “Жангар” туулийн дүрслэлтэй хэдийгээр дүрслэхүүн, дүрслэгдэхүүний орон байрын өмнө хойнох дэс дараалал нь зөрөөтэй боловч цөм өмнө дээврийг бугын арьсаар дээвэрлэсэнээрээ адилхан байна. Уг дүрслэл дэх дүрслэхүүн болсон “бөө”-гийн тодотгол үг болох “өл” буюу “өл /

өлү/" нь бичлэг зурлагын хувьд ялгаатай боловч нэг үгийн адил бус бичлэгийн зөрөө төдий. "Ноён Жангарын гэр" дэх "ар дээврийг нь алаг бухын арьсаар алтан хийсэн" гэх дүрслэл нь Овоолойн "Жангар" туулийн "ар биеэр нь өвөлжсөн улс айраг химирээр гарах гэж алаг бухын арьсаар өнгөлсөн" гэдэг дүрслэлтэй "ар" гэх дүрслэгдэхүүний зүг чиг болон "алаг бухын арьс" гэх дүрслэхүүнээрээ ижилсэж байна.

Тэгэхээр "Жоён Жангарын гэр"-ийн дээврийн дүрслэл нь "Жангар" тууль дахь өргөө гэрийн дээврийн дүрслэлтэй дээврийн зүг чиг болон материалын хувьд ижилхэн байна. Дээрх хоёр талын харьцуулаас үзвэл "Ноён Жангарын гэр" дэх Жангарын өвөг дээдэс хийгээд уг гарлын тухай дүрслэл нь "Жангар" тууль дахь Жангарын уг удмын дүрслэлтэй ижил мөртлөө ноён Жангарын гэрийн дээврийн дүрслэл нь ч "Жангар" тууль дахь Жангарын өргөөний дээврийн дүрслэлтэй зүг чиг болон материалын хувьд адил байна.

Ийнхүү уг удмын дүрслэл болон дээвэр дүрслэлээс үзэхэд "Ноён Жангарын гэр" нь "Жангар" туулиас улбаатай аман уламжлал болохыг тодруулж байна. Түүнчлэн энэхүү "Ноён Жангарын гэр" нь "Жангар" туулийн Сүвэй монголчуудын дунд дэлгэрч байсан аман уламжлалын эхлэлтийн хэсэг буюу оршил магтаалын хэсэг байна.

Даруй Сүвэй Монголчуудын дунд эрт үедээ "Жангар" туулийн уламжлал байсан мөртөө түүний зарим хэсэг нь шинэ гэрийн мялаалгын найрын дуу, гэрийн ерөөл буюу магтаалын хэлбэрээр уламжлагдан тархаж байв. Эрдэмтэн Т.Таяагийн "Хээрийн байцаалтаас үүдэн "Жангар" туулийн тархалтын арга замыг өгүүлэх нь" гэх өгүүлэлд "XX зууны эхэн үеэр дээд монголд бас Жангар дэлгэрч байсан мөртлөө жангарчид маш олон байжээ.

Тэдгээр Жангарчдын олонх нь Монгол үндэстэн байснаар барахгүй төвд үндэстэн ч байв. Сонгоров (XX зууны эхээс 1983 он) бол төвд гаралтай жангарч байсан ажээ. Түүний аав нь төвд, ээж нь монгол үндэстэн байсан бөгөөд бага насанд нь аав, ээж хоёр нь нас барснаас нэгэн хотон хүн асарч өсгөсөн юм. Багадаа сүмд сууж гэлэн болсон боловч хожим нь сүмээс салж хар болсон байв.

Тэрээр "шилт улаан хонгорын бүлэг", "Хүчит хүрмэн хааны бүлэг" ба "догшин малиа хавхын бүлэг" зэргийг хайлдаг байсан. Бүргэдвэй бээр

1955-1956 оны үед жангарч Сонгоровоос "шилт улаан хонгорын бүлэг"-ийг сурчээ. 1957 оны намар Сонгоров, Бүргэдвэй зэрэг Жангарчид нь Гансу мужийн Сүвэй шианаас Шинжааны Ховогсайрт нүүж ирээд одоогийн Ховогсайр монгол өөртөө засах шианы Цагаанхөл суманд нутаглажээ" (Таяа, 2003, х.60) хэмээн Сүвэй нутагт "Жангар" туулийн уламжлал байсан мөртлөө жангарч нь гадагшаа нүүж байсан тэмдэглэл бий. Цаашилбал, эрдэмтэн Т.Таяад 1999 оны 12 дугаар сард Сүвэй нутагтай Бүргэдвэй Жангарчаас дуу бичлэг хийсэн "шилт улаан хонгорын бүлэг"-ийн дуу бичлэг ч бий. Мөн судалгаа хийж явахад 2015 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн шөнө Сүвэй шианы наян дөрөвтэй Шагдар настны дурдсанаар, түүнийг бага байхад настайчууд "дэгэр дэгэр гэсэн морь нь \тэр газартаа хүрдэггүй\ тэгнэ тэгнэ гэсэн залуу нь тэр үгэндээ хүрдэггүй" гэж "Жангар" хайлдаг байсан гэлээ.

Эдгээр мэдээ нь XX дугаар зууны эхээр Сүвэй Монголчуудын дунд "Жангар" туулийн уламжлал байсан гэдгийг батлах нэг алхам болж байна. Ийнхүү зарим эрдэмтдийн судалснаар "XVII дугаар зууны гучаад оны сүүлчээр уг нутаг зүүнгараас урагш нүүдэллэж, Хөхнуур төвдийн өндөрлөгт хүрч нутагшсан хошууд аймаг буюу одоогийн дээд Монголчуудын дундаас ганц" бүлэг "Жангар" ч олдоогүй явдал нь их л сонирхолтой." (Мөнх, 2000) гэх мэтийн үзлийн зөв эсэхийг дахин бодолхийлэх хэрэгтэй байна.

ДҮГНЭЛТ

Энэ харьцуулсан судалгааны хүрээнд дараах хэдэн дүгнэлтийг хийж болохоор байна.

-Сүвэй Монголчуудын магтаал дуу "Ноён Жангарын гэр" дэх ноён Жангарын уг удмыг танилцуулсан дүрслэл болон өргөө гэрийн талаарх дүрслэл нь Халимаг буюу Шинжааны "Жангар" туулийн Жангарын уг удам хийгээд өргөөгийн дүрслэлтэй адилхан байна.

-“Ноён Жангарын гэр” дэх Жангарын уг удмыг танилцуулсан дүрслэл болон өргөө гэрийн дүрслэлээс үзэхэд дараа нь Сүвэй Монголчуудын дунд уламжлагдсан “Жангар” туулийн аман уламжлалын нэг хэсэг мөн гэх үзэл дэвшүүлж болохоор байна. Үүнийг бусад эрдэмтдийн судалгааны материалууд болон миний судалгаа ч давхар баталж байгаа болно.

-Ийнхүү зарим эрдэмтдийн Оросын холбооны Халимаг, Дундад улсын Шинжаан, жич Монгол улсын баруун хэсгээс өөр орон нутагт “Жангар”

туулийн уламжлал байсангүй гэх өрөөсгөл үзлийг дахин тунгаан бодох хэрэгтэй хэмээх саналыг дэвшүүлж байна.

Тайлбар :

① - Өвөрмонголын их сургуулийн Монгол судлалын дээд сургуулийн профессор Т.Таяагийн хадгаламжид 17 минут 44 секундын дуу бичлэг бий.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Алтан-Оргил. (1995). *Жангарын шарын дөрвөн төр*. Хөх хот: Өвөрмонголын соёлын хэвлэлийн хороо
- Таяа, Д. (2013). *Аримпилын “Жангар” хорин гурван бүлэг*. Хөх хот: Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо
- Таяа, Д. (2006). *Зуунайн гар бичмэл “Жангар”*. Хөх хот: Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.
- Ланзай. (2004). Жангар тууль монгол даяар тархаж чадаагүйн учир шалтгаан. “*Эрдэм шинжилгээний сэтгүүл*” *ӨМБИС*. №3. Хөх хот
- Мөнх, Б. (2000). Жангар туулийн тархцаас түүний үүсэн төлөвшсөн цаг, орныг тодруулах нь. *Өвөр монголын нийгмийн шинжлэх ухаан*. №4. Хөх хот
- Таяа, Д. (2012). *Овоолойн “Жангар” арван бүлэг*. Хөх хот: Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо
- Төвийн үндэстэний дээд сургууль. (1984). *Монгол уран зохиолын түүх*. Хөх хот: Өвөрмонголын сурган хүмүүжлийн хэвлэлийн хороо.
- Таяа, Д. (2003). Хээрийн судалгаанаас үүдэн Жангар туулийн тархалтын арга замыг өгүүлэх нь. *Монгол хэл утга зохиол*. №6. Хөх хот
- Чойдандар, Ц. (2014). *Сүвэй монгол ардын аман зохиол*. Хөх хот: Үндэстний хэвлэлийн хороо
- Дэлэг, Ж. (2012). “Жангар” туулийг судлахуй. <http://www.urlag.mn/>